

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Үйлст эмнэхүй өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2024 он	Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	6-11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЗД	Засаг дарга
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ҮЙЛСТ ЭМНЭХҮЙ
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ч.ОТГОНЗАЯА ТАНАА

2024.08.23 № 020-2024/26-НД-ӨТД-ННЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Үйлст эмнэхүй өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Мандал сумын Үйлст эмнэхүй өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон **6,335.0** мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасантай болон Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 6 дугаар хавсралттай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд шинээр иргэдэд үзүүлэхээр зөвшөөрөгдсөн 4 төрлийн тусламж үйлчилгээнээс сэргээн засах, өдрийн эмчилгээ зэрэг 2 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн 5,540.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

ӨЭМТ нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжиж “Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл” гэсэн хариуцлагын хэлбэртэйгээр хүн амд эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд санхүүгийн тайлан нь төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, тайлагнагдах зохицуулалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймаг дахь ЭМДХ нь ӨЭМТ-тэй байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ”-г ЭМДҮЗ-ийн 07 дугаар тогтоолд заасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэж, “Хангалттай” буюу 85.8 хувьтай үнэлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 сарын 22-ны өдрийн А/104 дугаар тушаалаар батлагдсан “Журам, гэрээний загвар шалгуур үзүүлэлт батлах тухай” журмын дагуу аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газрын дарга нь ӨЭМТ-ийн даргатай гэрээ байгуулж, санхүү болон үйл ажиллагаанд хяналт тавиагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,063,809.15	33,454,111.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,431,349.15	4,145,971.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,431,349.15	4,145,971.82
3121	Төгрөг	8,431,349.15	4,145,971.82
31211	Төрийн сангийн харилцах	8,431,349.15	4,145,971.82
33	АВЛАГА		26,636,795.00
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		26,636,795.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,632,460.00	2,671,344.84
351	Түүхий эд материал	8,632,460.00	2,671,344.84
3513	Эм боох материал	8,632,460.00	2,671,344.84
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	51,460,846.81	46,120,080.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	51,460,846.81	46,120,080.78
392	Биет хөрөнгө	51,460,846.81	46,120,080.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,892,560.85	56,235,550.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,440,656.62	-22,803,427.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,311,900.00	27,072,625.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,302,957.42	-14,384,668.46
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	68,524,655.96	79,574,192.44
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	68,524,655.96	79,574,192.44
51	Засгийн газрын хувь оролцоо	68,524,655.96	79,574,192.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,833,662.00	12,833,662.00
51101	Өмч: - төрийн	12,833,662.00	12,833,662.00
512	Хуримтлагдсан үр дүн	55,690,993.96	66,740,530.44
5121	Өмнөх үеийн үр дүн	55,690,993.96	55,690,993.96
5122	Тайлант үеийн үр дүн		11,049,536.48
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	68,524,655.96	79,574,192.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	452,075,172.16	383,793,609.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,570,887.16	7,879,138.27
120	Нийтлэг татварын бус орлого	22,570,887.16	7,879,138.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,570,887.16	
120004			
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,570,887.16	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		1,524,725.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		6,354,412.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,504,285.00	375,914,471.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	136,295,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,295,400.00	
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	293,208,885.00	375,914,471.06
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	293,208,885.00	375,914,471.06
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	422,339,128.46	372,744,072.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,339,128.46	372,744,072.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,039,128.46	362,744,072.85

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,529,737.09	247,901,049.52
210101	Үндсэн цалин	200,105,336.09	247,901,049.52
210102	Нэмэгдэл	39,424,401.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,894,210.51	28,985,132.87
210201	Тэтгэврийн даатгал	28,894,210.51	28,985,132.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,745,550.00	5,669,250.00
210302	Түлш, халаалт	5,480,750.00	5,369,216.00
210303	Цэвэр, бохир ус	264,800.00	300,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,808,443.87	16,942,514.00
210401	Бичиг хэрэг	3,108,100.00	1,804,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,663,439.00	3,788,679.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,370,730.00	534,665.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	208,400.00	222,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,457,774.87	10,592,170.00
2105	Нормативт зардал	90,555,243.87	38,401,568.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	86,855,243.87	37,441,568.03
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,700,000.00	960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,650,550.00	1,311,800.00
210604	Урсгал засвар	5,650,550.00	1,311,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,537,105.00	6,795,900.00
210702	Дотоод албан томилолт	4,537,105.00	6,795,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,731,704.00	2,236,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,602,400.00	1,538,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,904.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		637,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	63,400.00	60,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,586,584.12	14,500,758.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,282,120.00	2,056,277.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,304,464.12	12,444,481.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,300,000.00	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,300,000.00	10,000,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		4,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,300,000.00	5,400,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	29,736,043.70	11,049,536.48
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	29,736,043.70	11,049,536.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	429,504,285.00	349,277,676.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,504,285.00	349,277,676.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	136,295,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,295,400.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	293,208,885.00	349,277,676.06
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	293,208,885.00	349,277,676.06
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	421,091,942.60	353,563,053.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,091,942.60	353,563,053.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	415,291,942.60	343,563,053.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,529,737.09	247,901,049.52
210101	Үндсэн цалин	200,105,336.09	247,901,049.52
210102	Нэмэгдэл	39,424,401.00	

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,894,210.51	28,985,132.87
210201	Тэтгэврийн даатгал	28,894,210.51	28,985,132.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,745,550.00	5,669,250.00
210302	Түлш, халаалт	5,480,750.00	5,369,216.00
210303	Цэвэр, бохир ус	264,800.00	300,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,256,396.00	16,942,514.00
210401	Бичиг хэрэг	3,108,100.00	1,804,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,663,439.00	3,788,679.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,370,730.00	534,665.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	208,400.00	222,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,905,727.00	10,592,170.00
2105	Нормативт зардал	79,184,480.00	26,086,040.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,484,480.00	25,126,040.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,700,000.00	960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,130,640.00	6,890,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,531,090.00	3,737,990.00
210602	Тавилга	5,949,000.00	1,841,000.00
210604	Урсгал засвар	5,650,550.00	1,311,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,537,105.00	6,795,900.00
210702	Дотоод албан томилолт	4,537,105.00	6,795,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,731,704.00	2,236,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,602,400.00	1,538,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,904.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		637,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	63,400.00	60,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,282,120.00	2,056,277.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,282,120.00	2,056,277.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,800,000.00	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,800,000.00	10,000,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		4,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,800,000.00	5,400,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,412,342.40	-4,285,377.33
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,412,342.40	-4,285,377.33
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,431,349.15
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,145,971.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,833,662.00	55,690,993.96	68,524,655.96
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
17	Тайлант үеийн үр дүн		11,049,536.48	11,049,536.48
18			
19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,833,662.00	66,740,530.44	79,574,192.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	349,877,700.00	353,563,053.39	-3,685,353.39	101.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,877,700.00	353,563,053.39	-3,685,353.39	101.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,877,700.00	343,563,053.39	6,314,646.61	98.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,160,000.00	247,901,049.52	-8,741,049.52	103.65
210101	Үндсэн цалин	239,160,000.00	247,901,049.52	-8,741,049.52	103.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,895,000.00	28,985,132.87	909,867.13	96.96
210201	Тэтгэврийн даатгал	29,895,000.00	28,985,132.87	909,867.13	96.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,580,000.00	5,669,250.00	-1,089,250.00	123.78
210302	Түлш, халаалт	3,680,000.00	5,369,216.00	-1,689,216.00	145.90
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,034.00	34.00	100.01
2104	Хангамж, бараа материалын зардал	18,396,000.00	16,942,514.00	1,453,486.00	92.10
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,804,400.00	4,400.00	100.24
210402	Тээвэр, шатахуун	4,560,000.00	3,788,679.00	771,321.00	83.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	996,000.00	534,665.00	461,335.00	53.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	222,600.00	17,400.00	92.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,800,000.00	10,592,170.00	207,830.00	98.08
2105	Нормативт зардал	37,200,000.00	26,086,040.00	11,113,960.00	70.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,800,000.00	25,126,040.00	-2,326,040.00	110.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	960,000.00	40,000.00	96.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	6,890,790.00	-390,790.00	106.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,900,000.00	3,737,990.00	162,010.00	95.85
210602	Тавилга	2,000,000.00	1,841,000.00	159,000.00	92.05
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,311,800.00	-311,800.00	131.18
2107	Томилолт, зочны зардал	4,560,000.00	6,795,900.00	-2,235,900.00	149.03
210702	Дотоод албан томилолт	4,560,000.00	6,795,900.00	-2,235,900.00	149.03
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,400,000.00	2,236,100.00	163,900.00	93.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,538,800.00	-38,800.00	102.59
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	640,000.00	637,000.00	3,000.00	99.53
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	70,000.00	60,300.00	9,700.00	86.14

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,056,277.00	-56,277.00	102.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,056,277.00	-56,277.00	102.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,686,700.00	10,000,000.00	-313,300.00	103.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,686,700.00	10,000,000.00	-313,300.00	103.23
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,500,000.00	4,600,000.00	-100,000.00	102.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,186,700.00	5,400,000.00	-213,300.00	104.11
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	349,877,600.00	349,277,676.06	599,923.94	99.83
134	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	349,877,600.00	349,277,676.06	599,923.94	99.83
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	349,877,600.00	349,277,676.06	599,923.94	99.83
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,431,349.15	8,431,349.15	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,145,971.82	4,145,971.82	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Үйлст эмнэхүй Өрхийн эрүүл мэндийн төв /цаашид ӨЭМТ гэх/ нь “Эрүүл иргэн эрүүл өрх уриатайгаар нийт хүн ам, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн чанартай, хүртээмжтэй соёлтой үйлчилгээг эрүүл мэндийн анхан шатны тусламжид тулгуурлан яаралтай тасралтгүй тэгш хүртээмжтэй үзүүлэх, үйлчлүүлэгчид инээмсэглэл эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх.” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн хүн бүрт үйлчлэх,
- Нотолгоонд тулгуурласан тусламж, үйлчилгээг үзүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох,
- Иргэн бүрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай, аюулгүй, чирэгдэлгүй, тасралтгүй үзүүлэх
- Тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлох, эмчлэх, сувилах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эрүүл мэндийг дэмжих, сэргээн засах, хөнгөвчлөх гэх мэт хүрээний дагуу үзүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- *Засгийн газрын 2023 оны 06 сарын 21 өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.*
- *2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 6 дугаар тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг шинэчлэн баталсан,*
- *2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 7 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Үйлст эмнэхүй өрхийн эрүүл мэндийн төв нь ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу нэг иргэний нормативаар тооцож олгох санхүүжилт, тусламж үйлчилгээний санхүүжилт зэрэг гүйцэтгэлийн санхүүжилтээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Гэвч төсвөөс олгож буй гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийн зарцуулалт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газраас хэрэгжилтийг дүгнэж, хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 79,574.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,049.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,431,3	4,145,9	-4,285,4
Авлага		26,636,8	26,636.8
Бараа материал	8,632,4	2,671,3	-5,961,1
Үндсэн хөрөнгө	51,460,8	46,120.0	-5,340.8
Нийт хөрөнгө	68,524.6	79,574.2	11,049.6
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	68,524.6	79,574.2	11,049.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	68,524.6	79,574.2	11,049.6

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 4,145.9 мянган төгрөг болж 4,285.4 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДС-ийн санхүүжилт дутуугаас шалтгаалан оны эхний дансны үлдэгдлээс тайлант онд зарцуулсантай холбоотой байна.
- Авлага дансанд ЭМДС-аас авах санхүүжилтийн 26,636,8 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 2,671.3 мянган төгрөг болж 5,961.1 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс тайлант онд бараа материал, эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 46,120.0 мянган төгрөг болж 5,340.8 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн яамнаас 1,524.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан, өөрийн хөрөнгөөр 5,578.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан болон тайлант онд 12,444.4 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2023 оны төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1 хөтөлбөр 1 арга хэмжээгээр тооцон ЭМДС-аас нэг иргэний нормативт санхүүжилтээр 350,420.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ЭМГ-аас тус эрүүл мэндийн төвийн ЭМДС-аас төвлөрөх санхүүжилтийг **349,877.7** мянган төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Гүйцэтгэлээр ЭМДС-ийн нэг иргэнээр тооцож олгох санхүүжилтээр 343,737.6 мянган төгрөг, эмчилгээ үйлчилгээний санхүүжилтээр 5,540.0 мянган төгрөг зэрэг 2 арга хэмжээний нийт **349,277.6** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж, оны эхний үлдэгдлээс 4,285.4 мянган төгрөгийг тайлант онд зарцуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний урсгал үйл ажиллагаанд **353,563.0** мянган төгрөгийг зарцуулж, 101.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **353,563.0** мянган төгрөг буюу 101.0 хувьтай тайлагнагдсан нь тайлант онд төлөвлөгдөөгүй шинэ тусламж үйлчилгээний 1 хөтөлбөр нэмэгдэж 5,540.0 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж, цалин, НДШ-ын зардалд 3,093.7 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 2,446.3 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнд ноогдох нормотивт /80302/	349,877.7	348,023.0	-1,854.7	99.5
2	Тусламж үйлчилгээний зардал		5,540.0	5,540.0	100
	Дүн	349,877.7	353,563.0	3,685.3	101.0

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шууд худалдан авах босго үнээс давсан 22,000.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр Азын нахиа, Архон, Монгол фарм, Доктор мэйк, эмийн сан, Архон фарм, Ультрафаз, Эм би жэй эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх төв зэрэг байгууллагуудаас шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үйлст эмнэхүй өрхийн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 422,339.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,335.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж, тайлагнасан боловч шууд худалдан авах босго үнээс давсан нийт 22,000.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20.0 сая төгрөг ажил 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар үе шатны ажлыг хэсэгчлэн хийх буюу түүвэрт хамруулан аудитыг гүйцэтгэсэн байна. Аудитаар ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **15,348.5** мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангаас эд хариуцагчийн эм, эмнэлгийн хэрэгслийн тайлангийн эхний үлдэгдэл нь 7,363.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан,
2. Орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй ирсэн 1,631.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгээгүй,
3. Үнэ төлбөргүй ирсэн бараа материалын орлогыг 6,354.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт **26,501.0** мянган төгрөгийн зөрчил² илэрч, 1,375.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 25,126.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Сарын цалингаас гадна тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийн орлогоос эмч, ажилтнуудад нийт **1,375.0** мянган төгрөгийн цалин нэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалт болон Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн *"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"* 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмч, ажилтнуудын цалинг шинэчлэн батлагдсан эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг үндэслэн шинэчлэн тогтоож, олгоогүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн *"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"* 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг шинэчлэн баталсан цалингийн сүлжээг үндэслэн тогтоох албан шаардлага хүргүүлэв.

2. 2023 оны жилийн эцэст эм, эмнэлгийн хэрэгслийн тооллого хийж тооцоо бодоогүйгээс бодит үлдэгдлийг санхүүгийн тайланд *Үлдэгдэлгүй тайлагнагдсан* тусгаж, тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ"*, 12.2.1: *"Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"*, 20 дугаар зүйлийн 20.2 дахь *"Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:"* 20.2.6 дахь *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Жилийн эцэст бараа материалын тооллого хийж, үлдэгдлийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Анхан шатны баримтгүйгээр зөвхөн эмийн зардлыг цуглуулах хүснэгтийг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийн **25,126.0** мянган төгрөгийн зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг бүртгээгүй,	1	1,631.1	1	1,631.1			1	1,631.1				
Үнэ төлбөргүй ирсэн бараа материалыг илүү бүртгэж тайлагнасан	1	6,354.4			1	6,354.4	1	6,354.4				
Санхүүгийн байдлын тайлангаас эд хариуцагчийн бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	7,363.0			1	7,363.0	1	7,363.0				
Дүн	3	15,348.5	1	1,631.1	2	13,717.4	3	15,348.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	1,375.0	1	1,375.0								
Бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүйгээс бодит үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй	1				1							
Цалинг шинэчлэн тогтоогоогүй	1				1							
Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан.	1	25,126.0			1	25,126.0						
Дүн	4	26,501.0	1	1,375.0	1	25,126.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	22,000.0					1	22,000.0
Дүн	1	22,000.0					1	22,000.0
Нийт дүн	1	22,000.0					1	22,000.0